



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/60

Улаанбаатар хот

Ой, хээрийн гал түймрээс
урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим
арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.12 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.1 дэх заалт, Улсын Онцгой комиссын 2024 оны "Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай" 02 дугаар албан даалгавар, Нийслэлийн Онцгой комиссын 2024 оны 02 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор ногоон бүсэд хяналт, шалгалт явуулах ажлын хэсгийг нэгдүгээр, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээний хүрээнд хийгдэх ажлын хуваарийг хоёрдугаар, үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн төсвийг гуравдугаар хавсралтаар баталсугай.

2.Дүүргийн ногоон бүсэд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулахад шаардагдах 1.751.180 (Нэг сая долоон зуун тавин нэг мянга нэг зуун ная) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

3.Холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хийсэн ажил, үр дүнг эргэн танилцуулж, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, нэгдсэн бодлого, удирдлагаар хангаж ажиллахын Онцгой байдлын хэлтэс (Б.Цогбадрах)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 07 сарын 08-ны өдрийн 1166 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ЯВУУЛАХ АЖЛЫН
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Цогбадрах	Онцгой байдлын хэлтсийн дарга хурандаа
Гишүүд:	Т.Лхагвасүрэн Д.Хүрэлбаатар Н.Нямзав Б.Батзориг Д.Хүрэлбаатар Н.Батболд	Цагдаагийн хэлтсийн дарга, хурандаа Тохижилт, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга 1-р хорооны Засаг дарга 2-р хорооны Засаг дарга Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга Мэдээлэл технологи хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн:	М.Мөнхболд	Гал түймрийн Улсын хяналтын байцаагч, ахмад

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 04 сарын 08-ны өдрийн 1/65 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ХАМГААЛАХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖЛЫН ХУВААРЬ

№	Зохион байгуулах албан тушаалтны нэр	Зохион байгуулах байгууллага	Хяналт, шалгалтад оролцох бүрэлдэхүүн	Ажиллах чиглэл	Шалгалт хийх хугацаа
1	Хурандаа Б.Цогбадрах	Онцгой байдлын хэлтэс	Гал түймрийн Улсын хяналтын байцаагч Гал түймэр унтраах, аврах 80 дугаар ангийн алба хаагчид	Хээрийн хоолой, Үнэгтэй, Хуурайн худаг, Бөөгийн толгой, Өндөр дэл, Гэр овоо, Хангайн хөндий, Магнайн бууц, Гурван толгой, Алтгана овоо	Хавар 04-р сарын 08-ны өдрөөс 04-р сарын 21
					Намар 09-р сарын 20-ны өдрөөс 10-р сарын 03
2	Хурандаа Б.Цогбадрах	Онцгой байдлын хэлтэс	Гал түймрийн Улсын хяналтын байцаагч Цагдаагийн хэлтсийн алба хаагчид		Хавар 04-р сарын 22-ны өдрөөс 05-р сарын 05
					Намар 10-р сарын 04-ний өдрөөс 10-р сарын 17
3	Хурандаа Б.Цогбадрах	Онцгой байдлын хэлтэс	Гал түймрийн Улсын хяналтын байцаагч 1 дүгээр хорооны ажлын алба Гал түймэр унтраах, аврах 80 дугаар ангийн алба хаагчид		Хавар 05-р сарын 06-ны өдрөөс 05-р сарын 19
					Намар 10-р сарын 18-ны өдрөөс 10-р сарын 31
4	Хурандаа Б.Цогбадрах	Онцгой байдлын хэлтэс	Гал түймрийн Улсын хяналтын байцаагч, Мэдээлэл технологи хариуцсан мэргэжилтэн, Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс		Хавар 05-р сарын 20-ны өдрөөс 06-р сарын 02
					Намар 11-р сарын 01-ний өдрөөс 11-р сарын 10
5	Хурандаа Б.Цогбадрах	Онцгой байдлын хэлтэс	Гал түймрийн Улсын хяналтын байцаагч 2 дугаар хорооны ажлын алба		Хавар 06-р сарын 03-ны өдрөөс 06-р сарын 10

Тайлбар: Хяналт, шалгалтын хэсгүүд нь эргүүл, хяналт шалгалтыг 14 хоногт 2 удаа зохион байгуулж эргүүл, хяналт шалгалтаар ажилласан тухай дүнг 14 хоног тутамд Онцгой байдлын хэлтэст ирүүлнэ.

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 04 сарын 04-ны өдрийн 1760 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт



ШААРДАГДАХ ШАТАХУУНЫ ТӨСӨВ

№	Материалын нэр	Нэг бүрийн үнэ	7 хоног тутам			Бүгд үнэ
			Литр	Хэдэн удаа	Нийт	
1.	A-92	2380	9,5	18	171	406.980

СУРГАЛТ, ДАДЛАГАД ШААРДАГДАХ ТӨСӨВ

№	Материалын нэр		Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх самбарын анонс		15м ²	26.000	390.000
2	Тараах материал		300ш	1000	300.000
3	Засаг даргын нэрэмжит үзлэг	Анонс	6м ²	26.000	156.000
		Тараах материал	200ш	100	200.000
4	Нэгдсэн сургалт, дадлага	Анонс	6м ²	26.000	156.000
		Бензин	30л	2380	71.400
		Дизель түлш	20л	3540	70.800
					1.344.200
Нийт					1.751.180